



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/295

Булган сум

### Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV дүгээр хуралдааны "Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2023 оны XIV/01 дүгээр тогтоолоор батлагдсан Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 54 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн гамшигт үзэгдэл хүчтэй салхи, шуурганы улмаас Булган аймгийн Рашаант сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр, спорт заал, гал тогоо, дотуур байрны барилгын дээвэр хууларч, яаралтай засварлах шаардлага үүссэнтэй холбогдуулан тус засварын ажлыг 119,901,897 (нэг зуун арван есөн сая есөн зуун нэг мянга найман зуун ерэн долоо) төгрөгөөр "Эрхэт чонос констракшн" ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг зураг төсвийн дагуу холбогдох норм, дүрэм, шаардлагын түвшинд шуурхай гүйцэтгэн хүлээлгэж өгөхийг "Эрхэт чонос констракшн" ХХК (Д.Хүрэлбаатар)-д даалгасугай.

3. Дээрх ажлын санхүүжилтийг хууль, журам, гэрээний дагуу байгаль хамгаалах сангийн байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ